



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 11/21

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 "б", 29.1.6 "а", Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хог тээврийн үйлчилгээтэй холбогдох хөрөнгийг блансаас бланст шилжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Эрдэнэ-Очир /ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга/

Нарийн бичгийн дарга: С.Ууганбаяр /Аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч/

Гишүүд: Р.Мөнхтогтох /Сайнцагаан сумын Засаг дарга, Мандалговь хотын захирагч/
Б.Отгонтөгс /Дундговь-Ус ОНӨҮГ-ын дарга/
Д.Мөнхцоож /Сайнцагаан сумын Хот тохижилтын газрын даргын үүрэг гүйцэтгэгч/
О.Мөнхзул /ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн/
О.Энхзул /Аймгийн Орон нутгийн өмчийн газрын бүртгэл хариуцсан мэргэжилтэн/
Л.Сүрэндолгор /Дундговь-Ус ОНӨҮГ-ын нягтлан/
Б.Цэрэндолгор /Дундговь-Ус ОНӨҮГ-ын нярав/
Ж.Болор-Эрдэнэ /Сайнцагаан сумын Хот тохижилтын газрын нягтлан/
Г.Ундармаа /Сайнцагаан сумын Хот тохижилтын газрын нярав/


020000008

Хоёр. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор батлагдсан төрийн болон орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг бүртгэж, Сайнцагаан сумын Хот тохижилтын газарт шилжүүлэхийг тус комисс /Н.Эрдэнэ-Очир/-т даалгасугай.

Гурав. Чиг үүргийн дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж үйлчилгээг тасралтгүй явуулахыг Сайнцагаан сумын Засаг дарга, Мандалговь хотын захирагч /Р.Мөнхтогтох/-д үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/75 дугаартай захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ